

## Хэсэг 11

# Орчин үеийн соёлын болон шашны төрх: Сүүлийн 20 жилд Монголд хөгжсөн Христийн шашны хөгжил

Жамсрангийн Пүрэвдорж

*Редакторын тайлбар:* Сүүлийн хориод жилийн хугацаанд Протестант эвангелийн христийн шашин Монголын нийгэмд томоохон нөлөө үзүүлсэн. Номлогч Ж.Пүрэвдорж эдгээр өөрчлөлтийн үйл явцад биечлэн оролцож байсны хувьд үүнийг дотоод талаас нь ажигласан ажиглалтаа энд нэгтгэн дурдсан байна. 1990-ээд оны эхэн үед Монголд үндсэндээ байхгүй байсан христийн шашин өдгөө 100 мянга орчим итгэгчидтэй болсон нь Монголын сонгуулийн насны нийт иргэдийн 10 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн талаар тэрээр тэмдэглэжээ.

Монгол дахь христийн шашны дэлгэрлийг гурван үе шатанд хувааж болох бөгөөд социализм нуран унах үед Монголчуудын сүсэг бишрэлийн хэрэгцээ нь нийгэм, соёлын сүлэлдсэн олон асуудлуудтай хамт урган гарсан гэж Ж.Пүрэвдорж номлогч өгүүлсэн байна. Тэрхүү дарамт болон шилжилтийн үед христийн шашин нь Монголчуудад, ялангуяа залуу үеийнхэнд материаллаг, хүмүүжил сургалтын, нийгмийн болон оюун санааны дэмжлэг үзүүлж байсан. Гадаадын номлогчид болон багш нараар дамжуулан христийн шашинд итгэх анхны итгэл нь Монголчуудын хамтын чиглэл болон хамтын манлайлал болсон талаар Ж.Пүрэвдорж гуай тайлбарласан байна.

Христийн шашин түгэн дэлгэрсэн замналыг шинжлэхэд ядуурлыг бууруулах, архидан согтуурал, гэмт хэргийг бууруулах, шоронгийн ялтнуудтай ажиллах зэргээр уг шашныхны зүгээс хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн үйлс нь нийгэмд эерэг үр дагавар бий болгосны зэрэгцээ цаашидаа Монголд христийн шашныг өргөнөөр түгэн дэлгэрэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.

*Түүний үзэж буйгаар христийн шашин өдгөө ч анх 1990-ээд онд дэлгэрсэн тэрхүү хурд, хүч нөлөөгөөрөө Монголд түгсээр байгаа ажээ.*

---

Социализмын уналтаас хойш Монголын нийгэмд өрнөсөн томоохон хөдөлгөөнүүдийн нэг нь шашин байв. Уламжлалт шашнаас гадна христ итгэлтнүүд (Christianity) өнөөгийн нийгэмд нилээн хурдацтай, өргөн далайцтай үйл ажиллагаа явуулах болоод байна.

Энд би Монгол дах “христийн” гэсэн хаягтай бүхнийг төлөөлөн ярьж чадахгүй боловч нийт христийнхний 90 гаруй хувийг эзэлж буй протестант үндсэн чиглэлийн, евангелийн итгэлтэй хүний хувиар ярих нь зүйтэй хэмээн бодож байна.

Уг хурлын зохион байгуулагчдын санал болгосны дагуу Монголын христийнхний сүүлийн 20 жилийн түүх, үүсэл, хөгжлийг тоймлон өгүүлье.

## **Үүсэл**

1991 оны хувьсгалтай яг зэрэгцэн эхэлсэн оюун санааны өөр нэгэн хувьсгал бол христ-итгэлийн хувьсгал юм. Христийн тухай мэдээ буюу евангел Монгол нутаг дэвсгэрт гурав дах удаагаа тархсан бөгөөд үүнийг бид христийн шашны гурав дах дэлгэрэлт гэж хэлж болох юм. Албан бус замаар, амаас амд дамжин тараагдсан евангел (орчуулбал сайхан-мэдээ) 1991 оноос эхлээд эрчээ алдалгүй түгсээр байгааг та бүхэн мэдэх билээ. Монголчууд яагаад христэд итгэлийг тийнхүү нээлттэй хүлээн авсныг баримттай дүгнэсэн судалгаа өнөөдөр байхгүй байгаа бөгөөд энд би зөвхөн өөрийн харж ажигласан дүгнэлтийг энд танилцуулж байгаа юм.

Социалист үзэл санаа нуран унахад хүмүүс оронд нь барьж авах, найдвараа тавих идеалыг алсуурхан эрсэн. Амьдрах найдвар, тулан босох итгэл үнэмшил тэдэнд

хэрэгтэй байсан. Монгол орон хоосорч, хүмүүст үнэн гэж юу вэ, амьдралын утга учир юу вэ гэх зэргийн метафизиксийн үндсэн асуултууд тулгарч, тэр бүхэнд хариулыг хайж байсан. Өмнө нь сонголтгүй, бэлэн өгөгдөж байсан бурхангүйн үзэл, тэр дундаа социалист итгэл үнэмшилд найдах найдвараа хүмүүс алдсан. Хүмүүний оршилд өөр утга учир байгаа эсэхийг эрэн хайж эхэлсэн яг тэр түүхэн цагт “мөнгө/эдийн засаг бол хүний амьдралын хамгийн чухал хүчин зүйл” гэсэн мэссэж нийгэмд давамгайлах болсны зэрэгцэн “орчлон бүтээгдсэн” тухай зарласан христийнхний мэдээ хүмүүст хүрч эхэлсэн. Хүмүүс христ-итгэлийг оюун санаа, сэтгэл, эдийн засгийн хэрэгцээг хангах, аливаа боломжид хүрэх, шинийг сурах, нөхөрлөл тогтоох, цагийг зөв өнгөрүүлэх зэрэг олон янзын зорилго, хандлагаар сонсож, сонирхож эхэлсэн. Тухайн үеийн хүмүүсийн амьдралын нөхцөл байдал, улс орны ядуурал тэднийг шинэ үзэл сурталд нээлттэй болгосон. Ялангуяа залуу үеийнхэн үүнд шинэ соргоогоор хандаж байв.

### **Хөгжил**

Монгол дах христийн шашны 20 жилийн хөгжлийг цаг хугацааны хувьд 3 ангилж болох юм. Үүнд: 1991-1995, 1996-2005, 2006- өнөөг хүртэл хэмээн авч үзнэ.

### ***1991-1995 он буюу бүрэлдэх тогтох үе***

Энэ үед хүмүүс ганц хоёроор бус, хэдэн арваараа, заримдаа зуу зуугаараа шийдвэр гарган итгэл олох хүслээр Христийн чуулганд хамрагдах болсон. Тэр үед 18-25 насны залуучууд ихэвчлэн хамрагддаг байсныг онцлон дурдах нь зүйтэй байх. Анхны итгэгчдийн дундаж нас 20-22 орчим байсан бөгөөд тэд бусдад түгээх, заах, удирдах гэх мэт гол ажлуудыг хийдэг байсан нь ихэвчлэн залуучууд, хүүхдүүдэд энэ мэдээ эхлэн хүрэх, тийм насны хүмүүсийг татах гол суваг нь болсон.

Өөрсдийн гэр орондоо, эсвэл албан байгууллагын өрөөг түрээслэн долоо хоног бүр цугларч, шинэхэн итгэлийн талаар судалж, ихэвчлэн Монголд суугаа гадны мэргэжилтнүүдийг урин хичээл заалгаж байлаа. Мэргэжил эзэмшсэн 22 орчим насны залуучууд тэдний гол цөм болж томоохон үүрэг гүйцэтгэсэн. Тэд хэл сурах, техник технологийн дэвшлийг таних, гадаад ертөнцтэй танилцах чин хүслийнхээ хажуугаар Христ-итгэл гэгч юу болохыг суралцаж байлаа. Монголд өрнөж буй Христийнхний өсөлт хөгжилтийн талаар сонссон гадаадын олон байгууллага, хувь хүмүүс Монголд анхаарлаа хандуулж үйл ажиллагаагаа эхэлсэн. Шашны эрх чөлөө хэрэгжиж буйг мэдэрсэн олон улсын төрийн болон төрийн бус байгууллагууд хүмүүнлэгийн ажилд хувь нэмэр оруулахаар ирсэн нь учраа олж ядан буй залуучуудад маш том түшиг тулгуур болсон юм.

Шинэхэн итгэлийг олсон залуучууд зохион байгуулалтанд орж, хөдөө орон нутгаар өөрсдийн итгэл үнэмшлийн талаар шургуу ухуулан сурталчилж, аймгийн төвүүдэд итгэгчдийг бий болгон, цуглаануудыг шинээр нээж байлаа.

Тиймээс чуулганууд өөрсдийгөө удирдах удирдагч бэлтгэх ажилдаа шамдан орсон бөгөөд энэ нь цэвэр гадныхны тусламж дэмжлэгээр хийгдсэн гэж хэлж болно. Монголд үүссэн ямар ч шинэ салбарт байдаг гадны мэргэжилтнүүдийн чиглүүлэг, мэргэжлийн зааварчилгаа бидэнд хэрэгтэй болсон. Гадны мэргэжилтнүүдийг авчирахад бидэнд хэд хэдэн хүндрэл учирсан. Нэгдүгээрт, үүссэн цуглаануудын 2% хүрэхгүй хэсэг нь улсын бүртгэлд бүртгүүлснээс бусад дийлэнхи нь гэр орноор цугларах хэлбэртэй байв. Тиймээс албан ёсоор гаднаас мэргэжилтэн урих нь хүндрэлтэй болж байв. Хэдийгээр албан ёсны бүртгэл авсан чуулганууд олширч эхэлсэн ч шашны визийг ихэнхи тохиолдолд зөвшөөрөхгүй байсан. Тиймээс бид богино хугацаагаар Монголд жуулчлан

ирэх багш, сүмийн ажилтнуудыг маш олноор урьж, заалгасан. Энэ нь биднийг зөвхөн Христийн тухай суралцахаас гадна гадаадын соёл иргэншил, түүх, сэтгэлгээг суралцах бололцоог нээсэн юм. Удирдлага бэлтгэх хүрээнд өрнөсөн энэхүү хөдөлгөөн бидний олон нөхөд гадаадын Библийн сургуулиудад суралцах түлхүүр болсон юм.

Удирдагчид түрэн гарч ирсэн тэрхүү үед гадны удирдлага багасаж, монголчууд өөрсдийн нутаг орны соёл, иргэншил, нөхцөл байдалд тохирсон үйл ажиллагаануудыг, өөрсдийн арга замаар хийх шаардлагатайг ойлгож эхэлсэн. Энэ нь гадны бүрэн удирдлага чиглүүлгээс, хамтарсан удирдлага уруу чиглэсэн он жилүүд байв. Энэхүү шилжилт одоо ч үргэлжилсээр байгаа юм.

Удирдагч бэлтгэх хүрээнд олон улсын чанартай, магадлан итгэмжлэлтэй Библийн нарийвчилсан сургалтуудыг зохион байгуулахаас гадна, хэд хэдэн чуулганы хүрээнд, орон нутгийн шинж чанартай жижиг лекц, сургалт, хөтөлбөрүүдийг олноор зохион байгуулсан. 1995-2000 оны үед Монголд буй чуулганууд нэгдэн өөрсдийн гишүүдэд үйлчилдэг, Библийн сургалтын төв, Монголын Эвангелийн Эвсэл гэх мэт томоохон шашны болон төрийн бус байгууллагуудыг байгуулснаар өөрөө өөрийгөө удирдан зохион байгуулах нөхцлийг бүрэлдүүлсэн.

Энэ хугацаанд Христийн чуулганууд хөдөө орон нутагт, ялангуяа сумын төвүүдэд үүсэн бий болсон. Мөн нийт чуулгануудын тоо 370 орчимд хүрч, 50,000 гаруй гишүүдтэй болсон.

Чуулганууд эвлэлдэн нэгдэж, итгэлийнхээ томоохон илэрхийлэл болох хүмүүнлэгийн ажлуудыг зохион байгуулж, олон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг эхлүүлсэн. Хүүхэд залуучуудад зөвлөгөө өгөх, хүмүүжил хөгжлийн асуудлуудаар лекц хийх, гэр бүл, настангууд, хүүхдүүдийг халамжлах гэх мэтийн оюун санаа, сэтгэлгээг хөгжүүлэх

үйл ажиллагааг зохион байгуулахаас гадна нийгмийн эмзэг давхрагынханд туслах санхүү болон сэтгэл санааны тусламж дэмжлэг үзүүлэх, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, гадаад хэл, соёл, дуу хуур сурах ажлуудыг хөгжүүлсэн. Бидний санаачлан хэрэгжүүлж буй олон талт, төрөл бүрийн эдгээр ажлуудыг нийгэм өнөөдөр ил тод харж байгаа билээ.

### ***2006-одоог хүртэл буюу төлөвшлийн үе***

Мэдээж 20 жилийн хөгжил гэдэг бол түүхийн үүднээс богинохон зурвас үе билээ. Хэдийн богинохон ч бүхэл бүтэн хөгжлийн цаг хугацаан дотор 2006-одоог хүртэлх энэ үе нь насанд хүрч, буурь суух гэж яваа хүнтэй зүйрлүүлж болох юм.

Удирдагч бэлтгэх үйл явц маань чуулганы тооны өсөлтөөс хол хоцорч яваа ч тодорхой хэмжээний үндэсний удирдагчидтай болж, олон чуулган, байгууллагууд цэвэр нутгийн удирдлагатай болсон. Албан ёсоор нийт 180 орчим пастор томилогдон ажиллаж байгаа бөгөөд зөвхөн Библийн сургалтын төв 350 орчим удирдагчдыг 2-4 жилийн хөтөлбөрөөр Библийн мэдлэг боловсролд сургасан байна.

Чуулгануудын удирдлага, тэдний туршлага сайжрахын хэрээр нийгэмтэйгээ хэрхэн зөв харьцаж, үйлчилж, зөв Монгол иргэнийг өсгөн төлөвшүүлэхэд ямар хувь нэмэр оруулж болохыг бага багаар ойлгон улам хөгжиж байгаа гэж би бодож байна.

Өнөөдөр Христийн чуулгануудын тоо 600 шахам, түүнд хамрагддаг итгэгчид 100,000 орчим болсон нь Христийн шашин яах аргагүй Монголын ардчилсан хувьсгал, зах зээл, даяарчлалын хөгжил дэвшилтэй зэрэгцэн хөгжин ирсэн манай нийгмийн салшгүй нэгээхэн хэсэг болсныг илтгэж байгаа юм.

### **Хөгжлийн хүчин зүйлс**

Христийн шашны өсөлт хөгжилтөд нөлөөлсөн хэд хэдэн үндсэн хүчин зүйлсийн талаар өөрийн санал, дүгнэлийг энд хэлэхийг хүслээ.

### **Оюун санааны орон зай**

Өмнө дурьдсанчлан, социалист үзэл баримтлал хүмүүсийн оюун санааны хэрэгцээг хангаж чадахгүй болж, хүмүүс харь гарагийн, ховсдогч, далдыг харагч, гал гаргагч хүн гэх мэт аливаа сонин хачин үзэгдэлд итгэхдээ амархан болсон. Тэрхүү оюуны хэрэгцээг хангахад олон зуун жилийн туршид хөгжсөн, хүн төрөлхтний итгэл үнэмшлийн томоохон өв болох Христийн шашин чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь Монголд шинэлэг үзэл санаа байсан тул хүмүүст, ялангуяа залуучуудын оюун санааны орон зайнд шинэ хувьсгал хийхэд нь нөлөөлсөн.

### **Эдийн засгийн хүчин зүйлс**

Ардчилсан хувьсгалын дараахан Монгол орныг эдийн засгийн хүнд нөхцөл байдал нөмөрсөн. Энэ үед гадны олон сайн дурын байгууллагууд тэр дундаа ихэвчлэн Христийнхний санаачлан үүсгэсэн хүмүүнлэгийн байгууллагууд Монгол улсад тулгараад байсан ядууралтай тэмцэхэд гар бие оролцож нэлээдгүй хувь нэмэр оруулсан. Ядуу айл өрхөөр явж, гурил будаа, хувцас хунар тараах ажилд хамрагдаагүй, түүний үр дүнг бага боловч амсаагүй хороо дүүрэг, аймаг сум байхгүй гэж би бодож байна. Энэ ажлын хүрээнд олон хүн Христийн чуулганд хамрагдах, евангелийг хүлээн авах боломжтой болсон.

### **Боловсрол ба хүмүүжил**

Христийн шашны өсөлт хөгжилтөд нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл бол боловсрол ба хүмүүжлийн хүчин зүйл хэмээн миний бие боддог. Гадаад хэл сурах, олон улсын хүмүүстэй танилцаж, шинийг сурч боловсрох шаардлага чухлаар тавигдаж ирэх тэр үед Христийн чуулганууд

Англи, Солонго, Япон гэх зэрэг хэлийг сурах боломжоор хангаж, боломжуудыг бий болгосон. Олон залуучууд гадаад ертөнцтэй холбогдохын тулд гадаад хүмүүсийг хайн сүм чуулганд ирдэг байв. Бие биетэйгээ нөхөрлөж, англи хэл сурч улмаар гадаадын сургуулиудад суралцахаар явсан залуучууд ч их байсан.

Хувь хүн өөрийн хэрэгцээг хангахаар ирдэг байсан боловч сүм чуулганы хүрээнд залуучуудад хэрэгтэй олон хүмүүжлийн ажлууд явагддаг байсан нь олон залуучуудыг ороо бусгаа нийгэмд өөрийгөө зөв залан авч явахад нь ач холбогдолтой байсан болохоор тэд сүм чуулган уруу татагдсан. Тэнд хүмүүжил, сахилга баттай байж, дотно нөхөрлөлийг бий болгож, тухайн үеийн нийгмийн бараан үзэгдэл болох архидалт, гэр бүл салалт, гэмт хэрэгт холбогдох зэргээс холуур байх боломжийг өгч байв. Чухамхүү архи болон гэр бүлийн асуудалтай хүмүүст өгөх зөвлөгөөнд сууж, тэгснээрээ сүм чуулганд хамрагдах болсон хүмүүс ч олон байлаа.

1990-ээд оны эхэнд Монголын засан хүмүүжүүлэх газрууд маш хүнд байдалтай, олон монгол залуус шоронд нас барж байсан. Тэр үед Христийн байгууллагууд тэдгээр газар очиж, хоригдогсод хоол, дулаан хувцас өгөн, улмаар сэтгэл санаагаар нь дэмжих хүмүүжлийн чанартай үйл ажиллагаануудыг явуулж байв. Хожим тэдний олон нь суллагдан нийгэмд орохдоо чуулгануудыг бараадан ирж байсан.

Хүүхдийн хүмүүжлийн асуудлаар эцэг эхүүд санаа зовж, хүүхдүүдээ чуулганы хүмүүжлийн ажлуудад сайн дураараа явуулж, зарим нөхцөлд дунд сургуулийн багш нар чуулганы ахлагч, пасторуудаар яриа хийлгэдэг байв. Боловсрол эзэмших гэхээсээ илүү хүмүүжих ажлын хүрээнд Христийн чуулганууд маш шургуу ажилласан нь олон хүн чуулганд татагдан хамрагдах боломжийг нээсэн юм.



Зөвхөн хүмүүжлийн ажил ч бус мөн эрүүл мэнд, хүүхдийн өмгөөллийн асуудал, мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд бизнес хөгжүүлэх, удирдлага зүй, амьдрах ухаан, урлаг, спорт гэх мэт олон боловсрол, сургалтын чанартай үйл ажиллагаануудыг хийж ирсэн нь хүмүүсийн амьдралд ач тусаа өгсөн. Эцэг эх, гэр бүлийн асуудлыг хөндсөн маш олон сургалтуудыг гадаадын олон орны сургалтууд дээр үндэслэн бий болгосон бөгөөд энэ нь ч өнөөдөр нийгэмд эерэг хандлагыг бий болгож байгааг бид бахархалтай хардаг.

### **Дүгнэлт:**

1990 он гэхэд огт байгаагүй Христийн шашин өнөөдөр Монголын хүн амын таван хувь шахамд хүрч, нийгмийн амьдралын маш олон талбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг хэсэг болсон байна. Үнэндээ улстөрчдийн дүгнэж байгаагаар сонгуулийн насны хүн амын 10 хувийг хамарч буй нь Монголын нийгэмд маш том нөлөөтэй болсныг харуулж байгаа юм. Даравч далдайна, булавч бултайна гэдгийг үлгэрээр Христигтэгчид нуугдахын аргагүй нүсэр болжээ.

Үүссэн цагаасаа эхлэн эрчимтэй өсөж буй Христийн шашны энэхүү эрч хүч одоо ч хэвээр байгаа бөгөөд цаашид энэ нь Монголын нийгэмд улам олон эерэг нөлөөг авчирах хандлагатай байгаа ба авчирах ч ёстой хэмээн би энд хариуцлагатайгаар илэрхийлж байна.

Төр засаг, нийгэм, хүн ардынхаа сайн сайхан өв соёлыг үргэлжлүүлэн дэлхийн улс үндэстэнд тунхаглах, нэр хүндийг нь өргөх, сайн үйлсийг улам илүүгээр дэлгэрүүлэх чин хүсэл тэмүүлэлтэй Христийнхний 20 жилийн товчхон түүх ийм болой.